



**АЙМГИЙН ОРОН НУТГИЙН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ЗАМЫН
БАЙГУУЛАМЖ СЭТЛЭХ АЖЛЫН ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ,
СЭРГЭЭН ЗАСВАРЛАХ, ГҮЙЦЭТГЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймагт шинээр инженерийн шугам сүлжээ барих, өргөтгөн шинэчлэх, засварлах болон бусад зорилгоор авто зам, замын байгууламжийг сэтлэх ажлын зөвшөөрлийг олгох, сэргээн засварлах, түүнд шаардагдах хөрөнгийг төвлөрүүлэн зарцуулах, ажлыг технологийн дагуу чанартай хийж гүйцэтгэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Авто зам, замын байгууламжийг сэтлэх зөвшөөрлийг мэргэжлийн байгууллагуудын техникийн нөхцөлийг үндэслэн Мэргэжлийн хяналтын газрын Авто замын улсын байцаагчийн дүгнэлт, Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгийн саналыг үндэслэн тухайн сумын Засаг дарга захирамжаар олгоно.

Хоёр. Зөвшөөрөл олгох үйл ажиллагаа

2.1. Авто зам, замын байгууламжийг сэтлэх үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн хүсэлтээ сумын Засаг даргад албан бичгээр гаргаж, тухайн гүйцэтгэх ажил, шугам сүлжээний ажил хийх зөвшөөрөл, техникийн нөхцөл, шугам сүлжээний ажлын зураг схем, ажил гүйцэтгэх график, зам сэтлэх болон нөхөн сэргээх байгууллагын тодорхой мэдээлэл зэрэг шаардлагатай материалуудыг хавсаргана.

2.2. Тухайн сумын Засаг дарга зам сэтлэх зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэний материалтай танилцаж, газар дээр нь үзэж судлахаас гадна 3 хоногийн дотор шийдвэр гаргана. Шугам сүлжээний гэнэтийн эвдрэл, гэмтэл болон байгалийн давагдашгүй хүчин зүйл тохиолдвол энэ хугацаа хамаарахгүй.

2.3. Байгалийн давагдашгүй хүчин зүйл болон шугам сүлжээний гэнэтийн эвдрэл гэмтлээр авто зам, замын байгууламжийг сэтэлсэн тохиолдолд Мэргэжлийн хяналтын газрын Авто замын хяналтын улсын байцаагч, холбогдох

эрх бүхий албан тушаалтан ажлын тоо хэмжээ, нөхөн сэргээхэд шаардлагатай төсөв тооцоог 7 хоногийн дотор багтааж энэ журмын дагуу сэргээн засварлана.

2.4.Авто зам, замын байгууламжийг сэтлэх зөвшөөрлийг авто зам сэтлэх, нөхөн сэргээх ажлын зардлыг хүсэлт гаргасан аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нөхөн сэргээх ажил гүйцэтгэх компаний дансанд төвлөрүүлсний дараа олгоно.

2.5.Зөвшөөрөл олгож буй сумын Засаг дарга захирамжид зам хаах, сэтлэх, шугам сүлжээ татах, өргөтгөх, зам нөхөн сэргээх өдөр, цагийг тодорхой тусгана. Гэнэтийн тохиолдлоос бусад үед зам сэтлэх, нөхөн сэргээх ажлын зөвшөөрлийг жил бүрийн 4 дүгээр сарын 15-ны өдрөөс 9 дүгээр сарын 15-ны өдрийн хооронд олгоно.

2.6.Авто замыг сэтлэх, нөхөн сэргээх ажлыг авто зам, барилга засварын ажлын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллагаар гүйцэтгүүлнэ.

2.7.Авто зам, замын байгууламжийг сэтлэх, нөхөн сэргээхэд замын хөдөлгөөн хаах, авто зам сэтлэх, шугам сүлжээ татах, өргөтгөх зэрэг бүх үе шатны ажилд энэ журмын 1.2-т заасан эрх бүхий албан тушаалтан болон аймгийн Засаг даргын Тамгын газрын авто замын асуудал хариуцсан мэргэжилтэн нар хяналт тавина.

2.8.Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах үүднээс зам дээр үйл ажиллагаа явуулах, зам хаах, хөдөлгөөний зохион байгуулалтын талаар захиалагч аж ахуйн нэгж, байгууллага, иргэн зам талбайн ажил эхлэхээс 72 цагийн өмнө телевиз, радио, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

Гурав. Авто зам сэтлэх үйл ажиллагаа

3.1.Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах үүднээс зам дээр үйл ажиллагаа явуулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь замын хөдөлгөөн хаах механик хаалт, тэмдэг заалт, ажил гүйцэтгэх хүн хүч, машин механизм, техник хэрэгслийн бэлтгэлийг хангах ба бэлтгэл ажил хангагдаагүй тохиолдолд зам сэтлэх ажлыг хойшлуулж, зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авна.

3.2.Авто зам сэтлэхдээ хөдөлгөөн зохицуулах техник хэрэгсэл, замын тоноглол, гудамжны тохижилт, тэмдэг, хайс, хашлагыг эвдэхгүй, зам талбайг бохирдуулахгүй байх бүхий л нөхцөлийг бүрдүүлнэ.

3.3.Авто зам сэтлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь зөвшөөрөлд заасан хэмжээний дагуу авто замыг сэтэлж, далан суурийг ухах ажлыг хийж гүйцэтгэнэ.

3.4.Авто зам сэтлэх үйл ажиллагаа явуулахдаа шугам сүлжээний болон холбогдох байгууллагын эрх бүхий этгээдийн албан ёсоор томилсон төлөөлөгчийг байлцуулна.

Дөрөв. Авто замын нөхөн сэргээлт хийх үйл ажиллагаа

4.1.Авто замын нөхөн сэргээх ажлыг авто зам барилга, засварын ажлын тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгж, байгууллага, захиалагчтай гэрээ хийж технологийн дагуу хийж гүйцэтгэнэ.

4.2.Энэ журмын 4.1-д заасан ажил гүйцэтгэх байгууллага нь авто замын зорчих хэсгийн хучилтыг хучилтын хийц, технологийн дагуу гэрээнд заасан хугацаанд гүйцэтгэж Засаг даргын томилсон ажлын хэсэгт хүлээлгэн өгнө.

4.3.Гүйцэтгэгчийн хийсэн ажлыг шаардлага хангасан гэж үзвэл ажлын хэсэг зохих журмын дагуу актаар баталгаажуулна.

Тав. Зам сэтлэх, нөхөн сэргээх үйл ажиллагааг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлага

5.1.Зөвшөөрөлгүй зам, талбай сэтэлсэн, зөвшөөрөл, гэрээнд заасан хугацаа хэтэрсэн, зөвшөөрөлд зааснаас илүү хэмжээгээр зам сэтэлсэн, нөхөн сэргээх ажлыг чанаргүй гүйцэтгэсэн зэрэг зөрчил үүсгэсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хуулийн дагуу захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

5.5.Зөвшөөрөлгүйгээр авто зам, замын байгууламжийг сэтлэхийг хориглох ба үүнийг зөрчсөн тохиолдолд түүнд ашигласан тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийг зохих журмын дагуу журамлаж, шаардлагатай тохиолдолд зөрчил гаргагчийн тусгайлан олгосон эрх хасах арга хэмжээ авна.